

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2006 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ-МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Соёлын өвийн төвийн 2006 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний бүтээгдэхүүний анги-1-д багтсан улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бурдүүлэх үйлчилгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хангаж ажиллалаа.

1.1 Түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх Маягт №2-ыг боловсруулах ажил

Монгол улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын бүртгэлийн маягт №1-ийг өнөөгийн шаардлагын түвшин Олон улсын музейн байгууллага ICOM-оос гаргасан бүртгэлийн стандарттай нийцүүлэн боловсронгуй болгох ажлыг мэргэжилтэн Ш.Энхтуяа, Д.Нарантуяа нар хариуцан гүйцэтгэлээ.

Эхний хувилбарыг 2005 оны 9-р сард бэлэн болгон Театрын музейн захирал Д.Цэдмаа, БСШУЯ-ны СУГ-ын мэргэжилтэн Д.Энхтөгс /Соёл, урлагийн газрын мэргэжилтэн байсан/ болон Дүрслэх урлагийн музей, Үндэсний түүхийн музей, Байгалийн түүхийн музей, Богд хааны ордон музейн эрдэм шинжилгээний ажилтнуудаар хэлэлцүүлэн санал авч, албан бичгийн хамт Соёл, урлагийн газарт хүргүүлсэн.

Шинэчлэгдсэн Маягт №2-ыг баталгаажуулах зорилгоор 1995 оноос эхлэн хэрэглэгдэж байсан маягт №1-ийн тушаал шийдвэрийг Үндэсний төв архивын газраас шүүн хүчингүй болголоо.

Монгол улсын соёлын өвийн бүртгэлийн Маягт №2 нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2006 оны 2-р сарын 28-ны өдөр 56 тоот тушаалаар батлагдсан.

Энэхүү маягтын дагуу “Монгол улсын соёлын өвийн бүртгэлийн маягт №2-ыг хөтлөх заавар” боловсруулан улс болон аймаг орон нутгийн бүх музей, Гандантэгчэнлэн хийд, Эрдэнэсийн сан, Үндэсний номын сан зэрэг газруудад албан ёсоор тараах ажлыг зохион байгууллаа.

Шинэчлэгдсэн Маягт №2 зохих түвшинд хийгдсэн гэж бид үзэж байгаа бөгөөд музейн үзмэр, түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах, электрон архив, тоон системд оруулахад зориулсан компьютерийн бүртгэлийн программыг зохиох ажлыг уг маягт дээр тулгуурлан хийх болно.

1.2 .1 Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах ажил

2006 онд “Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах-5” ажлыг Хэнтий, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь аймгийн хамран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн юм. Энэхүү ажлын хүрээнд БСШУ-ны сайдын 2001 оны 66 тоот тушаалын дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн мэргэжилтэн Ш.Энхтуяа, Д.Нарантуяа, Б.Даваацэрэн, инженер Д.Алтансух нар 2006 оны 6-р сарын 19-нөөс 11-р сарын 15-ны хугацаанд томилолтоор аймгийн музей дээр очиж ажиллан Хэнтий аймгийн музейн 219, Төв аймгийн музейн 224 ширхэг, Өмнөговь аймгийн музейн 215 ширхэг, Дархан-Уул аймгийн музейн 201 ширхэг, Сэлэнгэ аймгийн музейн 204 ширхэг үзмэр, Орхон аймгийн музейн 180 үзмэрийн гэрэл зурагийг 2-5 талаас нь авч, зарим шилдэг үзмэрийг дүрс бичлэгээр баримтжуулан, үзмэр бүрийг хэмжиж, жигнэн Маягт №2-ийн дагуу бүртгэл тодорхойлолтыг хийллээ.

Ажлын явцдаа музейн ажилтнуудад шинэчлэгдсэн маягтын дагуу бүртгэлийг хөтлөх, үзмэртэй харьцах талаар заавар зөвлөлгөө өгөх, музейн бүртгэлд буруу нэрлэгдсэн үзмэрийн нэрийг залруулах хэлж өгөх зэрэг ажлыг хийллээ. (Дэлгэрэнгүй тайлан СӨТ-д)

Түүнчлэн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд доорх музейнүүд үзмэрийн бүртгэлээ хийж ирүүлсэн байна.

Үүнд: Дундговь аймгийн музейгээс 55 ширхэг, Дүрслэх урлагийн музейгээс 5 ширхэг (гэрэл зураггүй), Данзанравжаагийн музейгээс 14 ширхэг, Говь-Алтай аймгийн музей 54 ширхэг, Эрдэнэ зуу музейгээс 126 ширхэг (гэрэл зураггүй) бүртгэл нийт 254 үзмэрийн бүртгэл ирүүлээд байна.

Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах ажилд багтах нэгэн томоохон ажил бол Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний “Тусгай захиалгат бүтээгдэхүүн”-ний

ангилалд багтсан “Чойжин ламын сүм музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах” ажил байлаа.

“Үндэсний соёлын өвийг тоон системд оруулан хадгалах” хөтөлбөрийн эхлэл, загвар ажил болгох зорилгоор Чойжин ламын сүм музейн үзмэрийг бүртгэлд бүрэн хамруулах тухай БСШУ-ны Сайдын 2005 оны 8 сарын 16 өдрийн 245 тоот тушаал гарч 2005 оны 9-р сарын 14-ны өдрөөс 2006 оны 6 сарын 5-ны өдөр хүртэл нийт 9 сарын хугацаанд Чойжин ламын сүм музейд бүртгэн баримтжуулах ажил хийгдлээ.

Бүртгэн баримтжуулах ажлаар тус музейн нийт 5147 ширхэг үзмэрийг хамруулж 2485 гэрэл зураг бүхий 1089 тодорхойлолт бичигдэж, уран барилгын хэсэг бүрийг харуулсан 230 гаруй гэрэл зураг авлаа. Дижитал аппаратаар үзмэр болон уран барилгын гадна дотно чимэглэл, сүмийн гадна талын чулуун баримлын гэрэл зургийг авч, Соёлын өвийн төвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн фондод авлаа.

2006 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар нийт 3000 орчим музейн үзмэр бүртгэн баримтжуулахаас 2586 музейн үзмэрийг бүртгэн авч, 160 негатив гэрэл зургийн хальсаар 4325 өнгөт гэрэл зураг авч, mini DVСАМ 64 минутын 3 ширхэг хальсаар дүрс бичлэгийг хийж бүртгэл мэдээллийн сан хөмрөгийг баяжууллаа.

(Дэлгэрэнгүй тайлан СӨТ-д)

1.2.2 “Монголын бурхны шашны урлаг” каталогийг хэвлэлд бэлтгэх ажил

Монголын таван музейн шилмэл 500 орчим шүтээн зураг, зээгт наамал, бар зургийн бүтээл хамрагдсан гэрэл зураг, монгол, англи тайлбар бүхий “Монголын бурхны шашны урлаг” каталоги хэвлүүлэх ажил Монголд анх удаа хийгдэж, манай байгууллага дээр төвлөрөн 2004 оноос эхлэн хэрэгжиж байгаа билээ. Энэ ажлыг сүүлийн саруудад эрчимтэй явуулж, энэ онд бүх тодорхойлолт текст бичилтийг бүрэн дуусгаж хянан дизайн хийхэд бэлэн болгохоор төлөвлөн ажилласан байна.

2006 оны 7-р сарын 06-наас 18-ны өдрүүдэд энэхүү төслийг хариуцсан Төвдийн сангийн менежер Сүю Бэрн ирж төслийн цаашдын үйл ажиллагааны талаар ярилцлаа. Тухайлбал: Бурхдын нэрийг монгол, англи, төвд, санскрит хэл дээр бичихээс гадна уйгаржин монгол, хятад хэл дээр бичихээр тохиролцож, уйгаржин монголоор бичих хүнийг тогтсон ба хятад хэлээр бичих хүнийг төвдийн сан хариуцахаар болсон зэрэг цөөнгүй асуудлаар тохиролцсон.

Одоогийн байдлаар бүх бүтээлүүдийн монгол, англи тодорхойлолт бичилтийн ажил дуусаж, хяналтын ажил хийгдэж байна. Англи тодорхойлолтыг хянах ажлаар төслийн орчуулагч, хянач Лхагвадэмчиг Лондон дахь Төвдийн сан явсан ба монгол тодорхойлолтыг хянах ажил энд 8-р сард хийгдсэн.

Одоо номны үндсэн 470 гаруй монгол, англи тодорхойлолт, бурхдын үндсэн нэрийг монгол, англи, төвд, санскрит болон уйгаржин монгол бичгээр бичиж эцсийн байдлаар бүрэн хянагдан дуусаж байгаа ба удиртгал болон 8 бүлгийн оршил тайлбарыг бичих ажил 70 гаруй хувьтай явж байна.

2007 оны 1-р улирлаас номны эх бэлтгэх ажил эхлэх ба 2007 оны 3-р улиралд хэвлэлтэнд орж, 500 хувь ном 2007 оны жилийн эцсээр монголд ирж үнэ төлбөргүй их дээд сургууль, шашны байгууллага, бүх музей, номын санд тараагдахаар ажлыг төлөвлөж байна.

1.3 Түүх, соёлын ердийн болон хосгүй үнэт дурсгалт зүйлд гэрчилгээ олгох

БСШУЯамны дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлд зэрэглэл үнэлгээ тогтоох Мэргэжлийн зөвлөлөөс түүх, соёлын “Ердийн” дурсгалд хамаарах 1700 дурсгалд гэрчилгээ олгоод байна.

Монголын улсын Засгийн газрын тогтоолоор 1995-2005 онуудад түүх, соёлын “Хосгүй үнэт” зэрэглэлд батлагдсан 11 музей, байгууллагын нийт 267 дурсгалд гэрчилгээ олгох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү ажлын хүрээнд гэрэл зургийн шаардлага хангахгүй буюу огт гэрэл зураггүй байсан 220 орчим хосгүй үнэт дурсгалуудын гэрэл зургийг 2-3 талаас нь авч баримтжууллаа.

Гэрэл зурагжуулах ажилд одоогийн байдлаар Гандантэгчинлэн хийд болон гадаадад үзэсгэлэнд явсан нилээд тооны дурсгалууд хамрагдалгүй үлдсэн байна.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалд зүйлд олгох батламж ГЭРЧИЛГЭЭ-г БСШУ-ын сайдын 2003 оны 255 тоот тушаалын хавсралтаар батлагдсан эх загварын дагуу 2 хувь

хэвлүүлэн, нэг хувийг УНБМСангийн сан хөмрөт, нэгөө хувийг “Хосгүй үнэт” дурсгалыг эзэмшигч байгууллагад нь албан ёсоор гардуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан сурталчлах ажлыг хийв.

(Дэлгэрэнгүй тайлан СӨТ-д)

1.4 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлах, мэдээлэх

УНБМС-нд цуглагдсан түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлах, мэдээлэх зорилгоор БСШУЯам, Соёлын өвийн төв, ЮНЕСКО-ийн MYK хамtran “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” CD-ROM-ыг бүтээж, оюутан сургач, бүх нийтэд зориуулан үнэ төлбөргүй тараах ажлыг 2005 оны 9-р сараас эхлэн 2006 оны 3-р сар хүртэлх хугацаанд хийж дуусгав.

Энэхүү CDROM-д багтсан дурсгалуудыг Монгол улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтооюуор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баримтлан сонгон авлаа.

Бүтээлд монгол нутаг дахь хамгийн алдартай, түүхэн үнэ цэнэ, шинжлэх ухааны ач холбогдолтой хадны зураг, бичээс, гэрэлт хөшөө, буган болон хүн чулуун хөшөө, булш хиргисүүр, эртний хотын туйр, сүм хийдийн үлдэгдэл, суварга зэрэг 369 ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын тухай ерөнхий мэдээлэл өгөх, 840 гэрэл зураг, 30 орчим археологийн гар зураг, 21 аймаг сумдын нутаг дэвсгэрт байрлах 2082 хөшөө дурсгалуудын талаарх нэгтгэсэн судалгааг багтаасан юм.

Мэдээлэл-танин мэдээхүйн чиглэлээр хийсэн энэхүү CDROM-д Соёлын өвийн төвийн хээрийн судалгаагаар цуглагдаж УНБМС-ийн сан хөмрөт хадгалагдаж байгаа хэрэглэгдхүүнийг ашигласан ба зохиогчын эрх нь тус байгууллага дээр харьялагдаж байна.

CDROM-д дээрх үндсэн мэдээллээс гадна:

- Монголын түүхийн үечлэл
- Үл хөдлөх дурсгалтай холбоотой хууль, эрх зүйн тогтоомжийн тухай эмхтгэл
- БСШУЯам, Соёлын өвийн төвөөс хэрэгжүүлж буй хөшөө дурсгалыг сэргээн засварлах, хадгалж хамгаалах үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааны товчлол бүхий мэдээллийг багтаалаа.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос энэ бүтээлд зориулж тэтгэлэг олгосон бөгөөд хээрийн судалгааны ажлыг хамtran зохион байгуулсан юм.

1.5 “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх

“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажил бол Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний “Тусгай захиалгат бүтээгдэхүүн”-ний ангилалд орсон байна. Энэхүү ажлын хүрээнд:

- Хамрагдаж буй 35 байгууллагад хөтөлбөрийг танилцуулсан албан бичиг болон хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажил, төлөвлөсөн хугацаа зэргийг багтаасан мэдээллийг албан ёсоор хүргүүллээ.

- Хөтөлбөрт хамрагдаж буй байгууллагуудад ирэх жилийн төсөвт интернетийн зардлыг тусгуулах талаар мөн албан бичигт дурьдсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь интернет шугам сүлжээ ашиглан хийгдэх юм.

- Төлөвлөгөө ёсоор хөтөлбөрийн хүрээнд энэ 2006 оны 3-4-р улиралд музейн үзмэрийг бүртгэх бүртгэлийн програм хангамжийг зохиох ёстой бөгөөд 2006 оны 8-р сард Соёл урлагийн сангийн зөвлөлийн хурлаар програм хангамж зохиоход шаардагдах төсвийн хагасыг батлан өгч ажлыг эхлүүлээд төлөвлөсөн хугацааны дагуу 2007 оны 1-р сард Харилцагчийн болон Мэдээлэл боловсруулах хоёр төрлийн програмыг бэлэн болгохоор ажиллаж байгаа ажлын гүйцэтгэл 2006 оны 12-р сарын 27-ны байдлаар 80 хувьтай байна.
- Үндэсний хөтөлбөрт төсөвлөгдсөн төсвийг 2007 оны улсын төсөвт суулгаж өгч Сангийн яам, Улсын их хурлаар батлууллаа.
- Ирэх 2007 оны 1-2-р улиралд хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудад тараагдах ёстой компьютер, мэргэжлийн гэрэл зургийн аппарат техник тоног төхөөрөмжийг нийлүүлэх тендерийг БСШУЯ-тай хамtran зохион байгуулна. 2007 оны 6-р сараас энэ тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчинг бэлтгэх сургалт семинар зохион байгуулагдана.

- Энэхүү хөтөлбөртэй холбоотой бүх мэдээллийг харилцагч 35 байгууллагад албан ёсоор өгч, ирэх 2007 оны ажлын төлөвлөгөөнд нь тусгуулахаар боллоо.

1.6 Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах

2006 онд ЮНЕСКО-гоос Говийн Ү догшин ноён хутагт Данзанравжаагийн жанч халсны 150 жилийн ойг дэлхий нийтэд тэмдэглэх болсон онцлог үйл явдалтай уялдуулан Соёлын өвийн УНБМСанд бүртгэгдсэн Данзанравжаагийн холбоотой дурсгалууд, Дорноговь аймгийн Данзанравжаагийн музейд хадгалагдаж буй V Догшин ноён хутагтын эдэлж хэрэглэж байсан эд зүйлүүдээс 38 дурсгалыг сонгон хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалд батлуулахаар БСШУЯамны дэргэдэх ТСДЗ-ийн зэрэглэл үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Мэргэжлийн зөвлөл хэлэлцэн V Догшин ноён хутагтын эд зүйлийг сонгон хэлэлцэж 7 ширхэг эд өлгийн зүйлийг нь Монгол улсын Засгийн газрын тогтооолоор түүх, соёлын “Хосгүй үнэт” дурсгалт зүйлийн жагсаалтад нэмж батлуулах нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн.

Энэхүү 7 дурсгалд Ноён хутагтын зохиосон “Саран хөхөөний намтар” жүжгийн зохиолын эх гар бичмэл, хутагтад өргөмжлэгдхөдөө өмсч байсан малгай, түүний гарын тамга, хэрэглэж байсан гавлын ясан эрхи, гуутай цул алтан бурхан, гавлын ясан аяга, түмэн мэсний бурхан буюу Ловон Бадамжунай бурхны хөрөг дүр зэрэг түүх, соёлыг өгүүлсэн ховор нандин дурсгалууд багтсан.

Ийнхүү нийт 274 дурсгал Монгол улсын түүх, соёлын “Хосгүй үнэт” зэрэглэлийн дурсгалаар батлагдаад байна.

СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ УРЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Соёлын өвийн төвийн 2006 оны бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний бүтээгдэхүүний анги-2-д багтсан түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хангаж ажиллалаа.

2.1 Музейн үзмэрийг сэргээн засварлах

2006 оны сүүлийн улирлын байдлаар

- Уран зургийн галерейн сан хөмрөгийн 32 ширхэг үзмэр бүтээлийг сэргээн засварлахаас 35 бүтээл засагдсан,
- МҮТМузейн түүх, угсаатны зүйн сан хөмрөгийн 47 ширхэг үзмэрээс 28 ширхэг үзмэр засагдсан,
- Богд хааны ордон музейн 41 ширхэг үзмэрээс 20 ширхэг үзмэр засагдсан,
- Монголын Театрын музейн 3 ширхэг үзмэр засагдаж байгаа,
- Чойжин ламын сүм музейн 24 ширхэг үзмэр тус засагдсан ба музейн үзмэр сэргээн засварлах ажил 80 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2 Хөшөө дурсгалаас хэв авах, хуулбар, консервац хийх

Энэ төрлийн хадгалалт, хамгаалалтын ажилд зориулсан төсвийг 2006 оны 8-р сард Соёл урлагийн сангийн хурлаар оруулан хэлэлцүүлж төсвийг баталсан ба 8-р сарын дунд хагаст Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтийн цогцолборт консервац хийх ажлыг 10 хоногийн хугацаатай хийж дуусгалаа.

“Өнгөт уул” төслийн хүрээнд дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэлээ.

Үүнд:

1. Өнгөтийн цогцолборт газар буй бүх хүн чулуу, амьтны дүрст хөшөө чулуун дээр үүссэн элдэв бохирдол болон урьд өмнө буруу технологоор нааж бохирдуулсан цавууг арилгаж цэвэрлэж,
2. Цэвэрлэгээ хийсний дараа хөшөөний ойр орчимд байгаа хагарч унасан хэсгүүдийг хайж нийлж болох хэсгүүдийг судлан тодорхойлж наах мөн хугарч салсан хөшөө чулууг нааж,
3. Эвлэж нийлсэн болоод хугарч салсан хөшөө чулууг наасны дараа бүх хөшөө чулуунуудыг бэхжүүлэгч бодис ПАРАЛОЙД В-72 болон BACKER уусмал бодисуудыг чулууны бүтцэд тохируулан найруулан бэхжүүлж,
4. Бэхжүүлэлт хийсний дараа бүх хүн чулуу, амьтны дүрст хөшөө чулуу, бусад хөшөө чулуун дурсгалын гар зургийг тусгай цаасан дээр

- хэмжиж гар зураглал үйлдэнэ. Мөн хөшөө чулууны одоогийн байрлаж байгаа байдлыг дэвсгэр зургийг үйлдэж, хөшөө чулууны байрлалыг дэс дараалан тодорхойлж зурж,
5. Консервац, сэргээн засварлалт хийх ажлын явцыг фото зураг болон дурс бичлэгээр баримтжуулах ба сэргээн засварлахын өмнөх болон явц, сэргээн засварласны дараах байдлыг харуулсан баримтжуулах гэрэл зургийг тодорхой тооны дурсгал дээр жишээ болгож авч УНБМС-нд хадгалав.

2006 оны 10-р сард Архангай аймгийн Чонон хөшөө хэмээх гэрэлт хөшөөг хамгаалах, бэхжүүлэх, хэв авах ажлыг хийж гүйцэтгэн хэвийг авч ирсэн ба одоо сэргээн завсарлах студид хэвний нөхөлт, бэхжүүлэлт, хэвнээс хуулбар хийх ажлыг хийж байгаа ба энэхүү ажлыг 2007 оны 1-р улиралд дуусгахаар төлөвлөж байна.

Хуулбарыг Засгийн газрын ордны төрийн түүхийн музейд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна.

2.3.1 Дурсгалт барилгын ханын зургийг сэргээн засварлах

Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч 5 хүний бүрэлдхүүнтэй баг 2006 оны 4-р сарын 03-наас 6-р сарын 28-ны өдрийг хүртэл Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэ зуу хийдийн Баруун зуу дуганы сэргээн засварлалтын ажилд оролцон ажиллалаа.

Энэ ажлаар Баруун зуугийн барилгыг бүхэлд нь буулгаж байгаатай холбогдон дотор нь байгаа бурхны шашны холбогдолтой ханын зургийг тусгай аргаар хуулж аван барилгыг баригдсаны дараа буцааж анхны төрх байдалд нь сэргээн засварлаж тавьсан юм. Монголд, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын түүхэнд манай сэргээн засварлагчид бие даан анх удаа сүм хийдийн барилгын хананд буй ханын зургийг хуулж авах, сэргээн засварлах, дэглэх ажлыг хийснээрээ онцлог болсон бөгөөд энэхүү ажил нь бидний цааш цаашдын ажил, мэдлэг боловсрол, дадлага ажилд ихээхэн түлхэц болсон гэж үзэж байна.

Ажлыг 2006 оны 6-р сарын 28-нд БСШУЯам, Эрдэнэ-зуу музейн захиргаа, “Сүлд уул” ХХК-ны ажилтан мэргэжилтнүүдээс бурдсан ажлын хэсэгт чанарын “сайн” дүнтэйгээр хүлээлгэн өгчээ.

2.3.2 Түүх, соёлын дурсгалт олдворыг сэргээн засварлах

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Нартын хадны Бургастайн амны агуйгаас олдсон эртний хүний дээлийг сэргээн засварлах ажлыг 2006 оны 2-р сараас 7-р сарын хугацаанд сэргээн засварлалт хамгаалалт хийж дуусгаад байна. Энэ газраас 2 ширхэг тортон даавуу, 1 ширхэг арьс илгэн эдээр хийсэн нийт 3 дээл манай төвд ирсэн юм. Дээлийг хог шороо, бохирдоос нь салгаж цэвэрлэн, чийшилт өгөн тэнийлгэж, эх дээлэндээ урвал өгөхгүй байгалийн гаралтай бүтээгдхүүн даавуу утас ашиглан, химиийн бодис уусмал ашиглан зарим сэргээн засварлалтын ажлыг хийлээ. З дээлийг тэнэгэр байдлаар нь хадгалж хамгаалах зорилгоор тус бүрт нь тохирсон ар дэвсгэр бэлдэн бэхэлж тогтоон тусгай жаазанд хийж, гэрлийн нөлөө, хуурай агаарын урсгалаас хамгаалах ажлыг хийгээд байна.

Дээлийг хамгаалахтай холбогdon энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг гадаадын судлаачидтай уулзалдан санал солилцсон ба ийм төрлийн дээл, даавуу эдлэлийг тусгай зориулалтын хөргөгч болон гэрлээс аль болох хол байлгахыг зөвлөж байсан юм. Мөн энэ эх үзмэр, эд өлгийн зүйлсийг үзмэр үзүүллэгт дэглэх тавихыг хориглож байгаа ба хуулбарыг хийж музейд дэглэх тавихыг ч санал болгон зөвлөлөө.

Хөшөө дурсгалаас хэв авч хуулбар хийн хадгалах, дурсгалт барилгын ханын зураг сэргээн засварлах, түүх, соёлын дурсгалт олдворыг сэргээн засварлах үйл ажиллагаа 95 хувийн биелэлттэй байна.

Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний 3.4-д заасны дагуу “Манлайлах ур чадвар, мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар” 2006 оны 11-р сарын 15-наас 11-р сарын 29-ны хугацаанд БНХАУ-д зохиогдсон “Ази, Африкийн зарим орнуудад зориулсан соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, менежмент” сэдэвт сургалтанд оролцлоо. Энэ сургалтанд 12 орны түүх, соёлын дурсгалыг хамгаалах чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд оролцсон ба олон улсад соёлын өв, дурсгалыг хэрхэн хамгаалах талаар менежментийг хэрхэн хийх, учирч байгаа бэрхшээл, олон улсын

байгууллагад нэгдэн ажиллахын ач холбогдол, хөгжингүй орнуудын энэ талаар зохиосон арга хэмжээ ажлын туршлага зэрэг олон асуудлаар лекц, ярилцлага хийсэн болно.

ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДААГҮЙ ХИЙГДСЭН БУСАД АЖИЛ

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай

Сангийн сайд, БСШУ-ны сайдын санаачилгаар 2006 оны 9-р сарын 10-наас 9-р сарын 18-ны өдрүүдэд түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт шалгалт, дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт Соёлын өвийн төв голлон оролцож ажиллалаа.

Ажлын хэсэг зарим музей, номын сангийн сан хөмөргийн хадгалалт, хамгаалалт шаардлагын төвшинд хүрээгүй, хамгаалалтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдаагүй байгааг тогтоов.

Энэ ажлын эхлэл болж Сангийн сайд, БСШУ-ны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111-р хамтарсан тушаалаар ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн соёлын өвийг хамгаалах тухай зарим асуудлыг багтаасан, нэг тэрбум төгрөгний төсөв өртөг бүхий 8 үндсэн ажлыг 2006 оны 4-р улирлаас эхлэн 2015 он хүртэл төлөвлөн хийж гүйцэтгэхээр боллоо.

Гурван сайдын хамтарсан тушаалын дагуу Монгол улсын Засгийн газрын 2006 оны 11-р сарын 15-ны өдрийн 269-р тогтоолоор баталгаажуулан 2006 оны 4-р улиралд энэ ондоо багтааж улсын нөөц хөрөнгөнөөс 21 аймгийн музейг орон нутгийн цагдаагийн хэлтэстэй дохиоллоор холбох, Богд хааны ордон музей, Үндэсний номын санг галын дохиололтой болгох, Эрдэнэ-зуу музейг иж бүрэн галын болон хулгайн дохиоллын системээр тоноглох ажлыг БСШУЯамны Соёл урлагийн газар, Санхүү, эдийн засгийн газар, Улсын мэргэжлийн хяналтын улсын алба, аймгийн Боловсрол, соёлын газартай хамтран хэрэгжүүлэх ажлыг хийж байна. 2007 оны 1-р улиралд багтааж энэхүү ажлын тайлан үр дүнг албан ёсоор төсөл хэрэгжүүлсэн газраас авна.

Улсын тооллогын удирдамж боловсруулах тухай

“Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 8.7-д “УНБМСанд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллогыг 4 жил тутамд соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна” хэмээн заасан боловч 1996 оноос хойш тооллого хийгдээгүй ирсэн байна.

БСШУЯам тооллогын ажлыг манай байгууллага дээр төвлөрүүлэн хэрэгжүүлэх болсны дагуу холбогдох хууль журмыг судлан “Музейнүүдийн сан хөмрөгт улсын тооллого явуулах ажлын удирдамж”-ын санал болон хавсралт “Музейн үзмэрийн ерөнхий бүртгэл”, “Актлах үзмэрийн жагсаалт”, “Хулгайд алдагдсан үзмэрийн бүртгэл”, “Дутсан, солигдсон үзмэрийн бүртгэл”-ийн маягтын загвар саналыг боловсруулан бэлэн болгоод байна. Мөн тооллого явагдахад шаардагдах төсөв зардлын тооцоог боловсруулж Засгийн газрын 2006 оны 11-р сарын 15-ны 269-р тогтоолоор баталсан төсөвт ажилд багтаан оруулж батлуулан 2007 оны төсвийн нэмэлт тодотголоор зардлыг баталгаажуулан ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн дотоод журам

УНБМСангийн дотоод журам 1995 онд анх хийгдснээс хойш өөрчлөгдөөгүй өдий хүрсэн бөгөөд холбогдох хууль, журам, нэр томьёо бүгд өөрчлөгдсөн мөн “Үндэсний соёлын өвийг тоон системд оруулан хадгалах” хөтөлбөрийн хүрээнд архивын тоног төхөөрөмжтэй болж, шинэчилсэн архивын бүртгэлийн системтэй болох тул Бүртгэл мэдээллийн сангийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах шаардлага зүй ёсоор гарсан юм. Үүний дагуу “Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн дотоод журам”-ыг боловсруулах ажлыг хийж эхлээд байна.

Гэрэл зураг авах гэрээ

БСШУ-ны сайдын 2001 оны 66 тоот тушаалын дагуу “Улс, аймгийн музейд хадгалагдаж байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийн гэрэл зургийг авч УНБМСанд баримтжуулан хадгалах” ажлыг 2001 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ жилээс

энэхүү гэрэл зураг авах, баримтжуулах ажлаа тухайн газартайгаа гэрээ байгуулан хийхээр "Гэрэл зураг авах гэрээ" боловсруулан, хэрэгжүүлж байна.

ТИКА байгууллагатай хамтран ажиллаж байгаа тухай

Монгол-Туркийн Засгийн газрын хамтарсан Түрэгийн үеийн хөшөө дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах ажлын хүрээнд 2006 оны 8-р сараас эхлэн 10-р сар хүртэлх хугацаанд Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Хөшөөт цайдамын дурсгал дахь Билгэ хааны хөшөө болон бусад дурсгалын хэвнээс хуулбар хийх ажлыг Улаанбаатар хотод Туркийн мэргэжилтэнтэй хамт манай сэргээн засварлагчид хийж гүйцэтгэлээ.

Монгол улсын маршал X. Чойбалсангийн эдлэлийг сэргээн засварласан тухай

Төрийн ордны өмнө байсан бунхант индрийг нүүлгэж байгаатай холбогдон X. Чойбалсангийн өмсөж байсан хувцасны эдлэл болох алтан эдлэл, товч зэргийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэн, шинээр баригдаж буй төрийн музейд хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Богд хааны ордон музейн гол хаалга, Найдан сүмийг сэргээн засварлах ажилд оролцсон тухай

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусlamжийн хүрээнд БХОМузейн Гол хаалгыг сэргээн засварлах ажлын 1-р үе шат өнгө будагны үндсэн эх өнгийг шороо тоосноос химиин тусгай бодис ашиглан цэвэрлэх, эх зураг бүхий модны хагархай ан цав гарсан хэсгийг бөглөж битүүлэх зэрэг нарийн чимхлүүр ажилд оролцож, ажлын туршлага солилцлоо.

Мөн Дэлхийн хөшөө чулуун дурсгалыг хамгаалах сангийн Австри мэргэжилтэнтэй хамтран Найдан сүмийн баганын модон дээрх үлгэр, байгалийн сэдэвтэй зургийг хамгаалах, бэхжүүлэх анхан шатны ажлыг хамтран хийж гүйцэтгэсэн байна.

Говь-Алтай, Өмнөговь аймгийн музейд сэргээн засварлалтын ажил хийсэн тухай

Өмнөговь аймгийн музейн хүсэлтээр тус аймгийн музейд байгаа 30 орчим тооны эвдрэл, гэмтэлтэй үзмэрийг сэргээн засварлах ажил болон бүртгэл мэдээллийн сангийн ажлын хамт 2006 оны 10-р сарын 09-нөөс 18-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ. Сэргээн засварлах ажлын хүрээнд 10 ширхэг танка зургандаа цэвэрлэгээ бэхжүүлэлт хийн өнгө тавих, 7 ширхэг уран зургийг цэвэрлэж нөхөн өнгө тавих, 8 ширхэг модон эдлэлийн эвдрэл, хугархай гэмтлийг засварлах, 3 ширхэг даавуу зөвлөн эдлэлийг оёж сэргээн засварлалаа. Мөн музейн сэлбэн засагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, сургалт, дадлага ажлыг хамтран хийв.

Говь- Алтай аймгийн мукщийн 3 ширхэг дэлгэмэл бурхдыг утаа хөө тортогноос цэвэрлэн, зарим хэсэгт будгийн засвар, хамгаалалт хийв.

Бусад. "Чингис хаан ба түүний өв залгамжлагч" үзэсгэлэнгийн хүрээнд ахлах сэргээн засварлагч С.Чинзориг 2006 оны 10-р сард Австри улсад очин сэргээн засварлах студи, лаборатортой танилцан туршлага судлаж ирсний үндсэн дээр өөрийн байгууллагад тохирсон сэргээн засварлах зарим ширээ,тоног төхөөрөмжийт хийхээр төлөвлөлөө.

2006 оны 12-р сард БНХАУ-ын түүх, соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн байгууллагтай хамтын ажиллагаа хөгжүүлэх, "Зүүн өмнөд Ази болон Африкийн зарим орнуудад зориулсан соёлын өвийг хамгаалах менежент" чиглэлээр сургалтанд СӨТ-ийн захиарл болон сэргээн засварлагч нар оролцож туршлага судлан зарим байгууллагатай хамтын ажиллаагаа хэрэгжүүлэх анхны оролдлогыг хийлээ.

ДҮГНЭЛТ

Соёлын өвийн төв нь 2006 оны ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 нэр төрлийн бүтээгдхүүнээс жилийн эцсийн байдлаар байдлаар 8 бүтээгдхүүнийг бүрэн нийлүүлсэн, 1 бүтээгдхүүнийг хагас нийлүүлэн үйл ажиллагааг үндсэн төлөвлөгөөт хугацааны дагуу биелүүлэхийн төлөө ажиллаж иржээ.

Хагас нийлүүлсэн 1 бүтээгдхүүн нь Архангай аймгийн музейн хашаанд байрлах Чонон хөшөө буюу Бугатын гэрэлт хөшөөний хуулбар хийх ажил юм. Хуулбарыг хийхэд цаг хугацаа их шаардагдаж байгаа ба хуулбар 2007 оны 1-р улиралд бэлэн болно. Хуулбарыг Төрийн түүхийн музейд хүлээлгэж өгөхөөр төлөвлөж байна.

БСШУЯамтай байгуулсан үндсэн үйл ажиллагаа болон тусгай захиалгат бүтээгдхүүнээс гадна цаг үеийн шаардлагаар гарч ирсэн нэмэгдэл захиалгат бүтээгдхүүн орж ирж байна. Үүнд Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын хамтарсан түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалалт, хамгаалалтыг сайжруулах тухай ажил, Монгол Туркийн засгийн газрын хамтарсан сэргээн засварлах ажил зэрэг томоохон ажлууд орж байна.

Иймд Соёлын өвийн төв бүхий л бололцоо хүчээр ажлыг зохион байгуулж, холбогдох бүтээгдхүүнийг бүрэн дүүрэн, чанартай гүйцэтгэх талаар анхааран ажиллаж ирсэн байна.

| | Бүтээгдэхүүний анги | Бүтээгдэхүүний нэр | Нийлүүлсэн | Хагас нийлүүлсэн | Нийлүүлээгүй |
|---|---|---|------------|------------------|--------------|
| 1 | Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх үйлчилгээ | 1.1 Түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэх Маят №2-ыг боловсруулан ажиллах | + | | |
| | | 1.2 Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах, сурталчлах | + | | |
| | | 1.3 Түүх, соёлын ердийн болон хосгүй үнэт дурсгалт зүйлд гэрчилгээ олгох | + | | |
| | | 1.4 “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” CD-ROM бүтээх | + | | |
| | | 1.5 “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх, программ зохиох | + | | |
| | | 1.6 Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах | + | | |
| 2 | Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээ | 2.1 Музейн үзмэрийг сэргээн засварлах | + | | |
| | | 2.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах, хамгаалж бэхжүүлэх | | + | |
| | | 2.3 Дурсгалт барилгын ханын зураг болон эртний хүний дээл сэргээн засварлах | + | | |

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ
2006 он

